БАТЛАВ

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

2025.01.28

ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫГ ТЕХНОЛОГИЙН ДАГУУ ӨНДӨР ДАРАЛТААР ШАТААХ ЗУУХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ҮЗҮҮЛЭЛТ

Зорилго

Булган сумын хэмжээнд гарах хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын өндөр хэмийн зууханд шатааж хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, овор хэмжээг багасгах зорилготой.

Нийлүүлэгчид тавигдах ерөнхий шаардлага:

- Нийлүүлэгч нь хог хаягдал шатаах зуух үйлдвэрлэгчийн албан ёсны гэрээт борлуулагч байх ба угсарч суурилуулах, ашиглалтын хэвийн ажиллагааг хангаж ажиллах чадамжтай, нийлүүлж байсан туршлагатай байх;
- Нийлүүлэгч нь хог хаягдал шатаах зуухыг Булган аймгийн Булган сум руу тээвэрлэх, угсарч, ажиллагаанд оруулах ба холбоотой гарах бүхий л зардлыг бүрэн хариуцна;
- Хог хаягдал шатаах зуух нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, 2023 оноос хойш үйлдвэрлэсэн шинэ байх;
- Хог хаягдал шатаах зуухыг нийлүүлснээс хойш нэг жилийн хугацаанд нийлүүлэгч нь өөрийн зардлаар шатаах зуухны хэвийн ажиллагааг хангах ба техникийн ажилтныг Булган аймагт ажиллуулахад гарах бүхий л зардлыг хариуцна;
- Шатаах зуухыг ашиглах явцад үйл ажиллагааны доголдол гарсан тохиолдолд заавар зөвөлгөөг өгч, холбогдох засвар үйлчилгээний заавар бүхий гарын авлагыг монгол хэлээр захиалагчид өгөх;
- Шатаах зуух нь Стандарт, хэмжилзүйн газраас авсан хүчин төгөлдөр хугацаатай тохирлын гэрчилгээтэй байх;
- Нийлүүлэгч нь захиалагчид шатаах зуух ажиллуулах аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон техникийн ашиглалтын дүрмийг монгол хэл дээр хэвлэж өгнө.

№	Техникийн үндсэн заалт	Үзүүлэлтүүд
1	Үндсэн шаардлага	Шаталтын үеийн температур мэдрэгчтэй; Үйлдвэрийн 2 жилийн баталгаат хугацаатай; Хурдан элэгдэх сэлбэг, зайлшгүй шаардлагатай туслах материалын жагсаалтыг гаргаж баталгаат хугацаанд үнэ төлбөргүй нийлүүлэх; Автомат удирдлагын функц бүхий удирдлагын системээр тоноглогдсон байх; Тоног төхөөрөмжийн үйлдвэрийн гэрчилгээ, техник ашиглалтын паспорттой байх; 2023 оноос хойш үйлдвэрлэсэн байна.
2	Шаталтын температур	1000-1200 ℃ хооронд
3	Шатаах камерын эзлэхүүн	1,84 мкуб-с багагүй багтаамжтай,
4	Шатаах хүчин чадал	100-150 кг/цаг (өдөрт 3-6 удаа) хэмжээтэй хог хаягдал устгах хүчин чадалтай.
6	Доторлогоо	Галын аюулгүй байдлыг хангасан галд тэсвэртэй материал болон хавтан (20мм зузаан)-аар хийгдсэн байх 1350˚С хүртэл галд тэсвэртэй;
7	Шатагчийн тоо (үндсэн камер)	1 ширхэг болон түүнээс дээш

8	Шатагчийн тоо (бүтэн шаталтын камер)	1 ширхэг;
9	Ажиллах хүчдэл	380v эсвэл 220v;
10	Хяналтын систем	Автомат удирдлага бүхий хяналтын самбартай, цагийн тохируулгатай. Яаралтай үед зогсоох удирдлагатай (Emergency stop) байх;
11	Шатаагч	Дизель, 3-7 кг
12	Аюулгүй ажиллагаа	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ашиглалтын зааварчилгааг Монгол хэл дээр бэлтгэсэн байх, ашиглагчийг нийлүүлэгч тал сургаж дадлагажуулах, ашиглалт аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах
13	Баталгаат хугацаа	2 жил
14	Угсралт суурилуулалт	Гүйцэтгэгч тал хариуцна.
15	Шатаах зуух байрлуулах байгууламж	Шатаах зуух байрлуулах байгууламжийг гүйцэтгэгч тал барьж, зуухыг суурилуулна.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ДАВААНЯМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА

А.ГАНТӨМӨР

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУН-ЭРДЭНЭ